



2019 ОНЫ
ЖИЛИЙН ТАЙЛАН

DARKHAN NEKHII JSC

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

www.nekhii.mn



7717-5555

АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ	03
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ	07
СТАТИСТИК МЭДЭЭ	14
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	17
КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ	20

Компаний оноосон нэр

Дархан нэхий ХК

Үйл ажиллагааны чиглэл

Хонины нэхий, ямааны арьс, үхрийн ширээр боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаа, үйлчилгээ

Компанийн албан ёсны хаяг Холбоо барих

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800
Шуудангийн хайрцаг : 901, Дархан нэхий
Утас: (976)-77175555
(976)-70378499
Факс: (976)-70373149

И-мэйл: info@nekhii.mn
Веб хуудас: www.nekhii.mn
Фэйсбүүк: Дархан Нэхий

Компанийн удирдлага

ТУЗ-ын дарга : Э.Батсайхан
Ерөнхий захирал : Б.Мягмар-Өлзий

Үүсгэн байгуулагдсан огноо

1972 он

Ажилчдын тоо

496



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид олон улсын чанар стандартын түвшинд хүрсэн, зах зээлд өрсөлдөх чадвар сайтай, арьс шир болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг шинэ болон шинэчилсэн технологиор үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд борлуулна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

Дуурсах нэртэй, дуудах хүчтэй, хамгийн чанартай, хамгийн хямд Монгол бүтээгдэхүүнийг Монголчууд өөрсдөө үйлдвэрлэх

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

БИДНИЙ УРИА

Дэвшлийг хэрэгжүүлэгч, ёс зүйг эрхэмлэгч, байгальд ээлтэй компани

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

ХЭХ

ТУЗ


Нэр дэвшүүлэх
хороо

Шагнал
урамшуулалын хороо

Аудитын хороо

Толгой компани

Өхин компаниуд



ДАРХАН НЭХИЙ ХК

ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН ХӨЛС



Нэхий Таннери ХХК

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл



Нэхий Гармент ХХК

Гутал, хувцас оёдлын үйлдвэрлэл



Як Трейд ХХК

Үйлдвэрлэл, худалдаа



Нэхий Трейд ХХК

Сүлжээ дэлгүүр, худалдаа үйлчилгээ



Гранд Як ХХК

Түрээс & Үйлчилгээ



Дэвжих Нэхий ХХК

Зээлийн үйлчилгээ



Нэхий Агр ХХК

Хоол үйлдвэрлэл & Үйлчилгээ



496 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад **9.8 %** -р өссөн.



Өмнөх онтой харьцуулахад цалин **7%** -р өссөн. Дундаж цалин 960,984.39 төгрөг байна.



“Нэхий Хотхон – 4 ээлжийн 80-н айлын 10 давхар барилгыг ашиглалтанд оруулж , гаднах хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлэгийг шийдвэрлэж нийгмийн асуудалд анхаарч, ажилчиддаа хөнгөлттэй нөхцөлөөр орон сууцтай болох боломжоор хангав.



ЗГ-ын ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд 6 цэг нээж, 200 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон жижиг үйлдвэрлэгчдийг хямд үнэтэй арьс, ширээр хангаж ажиллаж байна.



ДУА-ийн өсвөрийн сагсан бөмбөгчдийн аварга шалгаруулах “БАГА ОЛИМП ” тэмцээнийг жил бүр ивээн тэтгэж явуулсаар байна.



Дархан SOS хүүхдийн асрамжийн төвд хандив тусламж үзүүлж ажиллаа.

Дархан Нэхий ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа ил тодоор явуулж, нийгмийн хариуцлагын өндөр ёс зүйг баримталдаг. Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайханыг чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлж ажиллаж байна.

MNT'000	2017	2018	2019
Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг	179,390	115,848	232,492
Улсын өмнө хүлээсэн үүрэг	2,585,339	1,687,551	1,684,854
Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг	101,237	25,164	28,163



Ажилтнуудын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **50%** -р өссөн



Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг :


Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **10.6 %** -р өссөн



Улсын өмнө хүлээсэн үүрэг:

Өмнөх онтой харьцуулахад гүйцэтгэл **0.16 %** буурсан

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТ



ТОРГОН НЭХИЙ ГОЁЛЫН НААЛТ

2018 оноос эхлэн хагас үйлвэрлэлийн туршилтууд хийгдэж, 2019 онд масс үйлдвэрлэлд оруулсан. Энэхүү наалт нь хагарахгүй, хөлдөхгүй, хэрэглэгчидын хэрэгцээнд нийцсэн хир толбо бага болохоос гадна илгэн нэхийг сохирхолтой чамин болгохын сацуу үйлвэрлэлийн явцад өнгө туяаг жигдрүүлж, талбай ашиглалтыг 5-9% хүртэл нэмэгдүүлдэг байгаа.



НЭХИЙ ДЭЭЛ

2019 оны хувьд нэхий дээлний загварын 40%-ийг хөвөрдлөгөө оёдолтой технологит шилжүүлсэн ба энэ нь үндсэн материалын хувьд болон оёдол гүйцэтгэх хугацааг богино болгож, нэгж бүтээгдэхүүн дээр бүтээмжийг 38% өсгөж өгч байгаа.



ӨВЛИЙН БОТИНК

Нэмэлт хийсэн чийг татахгүй нэхий дотортой гүйцээн боловсруулж гоёлын өнгө засал хийсэн шир нь дээр Хятад улсын Mustang үйлдвэрийн Оросын зах зээлд нийлүүлдэг, шинэ технологийн TPR материалын эрэгтэй оффис загварын улыг туршин үйлдвэрлэлд нэвтрүүлж, худалдаанд гарч эхэлсэн эхэлсэн.



SNOW TOP

Сновый топ буюу “Цасан сор” цайруулах аргаар илгэн нэхийний үсийг сорлосон мэт будсан технологийг туршилт болон хагас үйлдвэрлэлийн туршилт хийгдэж одоо батлагдсан технологиор ТТТ-өөр будагдаж гарч байгаа.



ХҮҮХДИЙН АЯГАН УЛ

2019 онд чанарлаг загварлаг бүтээгдэхүүнээрээ тэргүүлэх зорилтын хүрээнд Хятад улсын Mustang үйлдвэрийн Оросын зах зээлд нийлүүлдэг, шинэ технологийн TPU материалын аяган улыг туршин үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн.

Термопластик полиуретан буюу TPU нь туйлын уян хатан, удаан эдэлгээтэй, гал, ус, үрэлтэнд маш тэсвэртэй материал. Түүний бүтэц нь гинжин хэлхээнд холбогдсон зөөлөн, хатуу сегментээс бүрддэг тул чийг татах хальтарч хагарч хөлдөх гэсэн асуудал үүсэхгүй.

Энэхүү аяган ул нь TPU аяган ул, дотуур ул, эсгий ул, ширэн болон нэхий улавч гэсэн 5 давхаргаас бүрдэнэ.



2019 ШИНЭ КОЛЛЕКЦИ



100%

MADE IN MONGOLIA



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Өмнөх онтой харьцуулахад хөрөнгө оруулалт гүйцэтгэл **491 %** -р өссөн, нийт хөрөнгө оруулалт 7,1 тэрбум.
Үүнд :



Шинэ үйлвэрлэлийн шугам **2,3** тэрбум



Зочид буудал **3,8** тэрбум



Шинэ салбар дэлгүүр **463** сая



Тоног төхөөрөмж **169** сая



Программын шинэчлэл **22** сая



Засвар үйлчилгээ **84** сая


Бусад хөрөнгө оруулалт **98** сая,

ГРАНД ЯК ЗОЧИД БУУДАЛ **ТУН УДАХГҮЙ**



СТАТИСТИК МЭДЭЭ


/2019 оны гүйцэтгэлээр/




НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО 496



АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА




АЖИЛТНУУДЫН НАСЖИЛТ




БОЛОВСРОЛЫН ТҮВШИН




БОРЛУУЛАЛТ




ЦЭВЭР АШИГ




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО





ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ



ТҮҮХИЙ ЭД ТАТАН АВАЛТ



ЧАНАР



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН / АУДИТЛАГДСАН /

MNT'000	2017	2018	2019
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,833,727	1,140,899	458,006
Дансны авлага	2,195,557	2,878,389	3,342,130
Зээл	1,350,066	1,988,372	3,238,470
Бараа материал	13,975,619	12,959,297	14,886,579
Дуусаагүй барилга	3,825,050	6,222,868	9,031,468
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	-	-	3,354,134
Үндсэн хөрөнгө	28,150,801	28,356,183	27,968,307
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	54,755,751	55,640,372	63,277,466
Дансны өглөг	1,745,652	2,400,587	3,951,110
Богино хугацаат зээл	-	1,987,312	3,493,542
Урт хугацаат зээл	8,665,600	6,250,000	8,000,548
Урьдчилж орсон орлого	1,409,556	1,585,766	3,793,916
НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,820,808	12,223,666	19,239,116
Хуримтлагдсан ашиг	14,783,507	15,242,394	16,754,205
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	42,934,943	43,416,706	44,038,350
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	54,755,751	55,640,372	63,277,466

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН / АУДИТЛАГДСАН /

MNT'000	2017	2018	2019
Борлуулалтын орлого	27,094,404	22,202,682	20,254,733
Түрээсийн орлого	650,665	638,995	669,038
Хүүний орлого	738,120	620,222	384,452
Бусад орлого	690,050	164,104	294,989
НИЙТ ОРЛОГО	29,173,239	23,626,002	21,603,212
ЦЭВЭР АШИГ	299,576	1,051,075	2,327,633
Ерөнхий ба удирдлага үйл ажиллагааны зардал	5,745,852	5,072,756	5,445,609
Үйлдвэрлэл болон бусад зардал	23,127,811	17,502,171	13,829,970
НИЙТ ЗАРДАЛ	28,873,663	22,574,927	19,275,578

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн одоогийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 03 сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгосон.

Ердийн гишүүдэд:

Эрдэнэдалайн Батсайхан
Равжаагийн Сүмбэнхүү
Далхжавын Батжаргал
Хумбагайн Золжаргал
Баасангийн Гэрэлмаа

Хараат бус гишүүдэд:

Бямбадашийн Мөнхбаяр
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл
Бат-Очирын Энхнавч
Цагааны Баттогтох

Аудитийн хороо

Цэдэвсүрэнгийн Алтангэрэл
Цагааны Баттогтох
Бямбадашийн Мөнхбаяр

Шагнал урамшуулаллын хороо

Хумбагайн Золжаргал
Бямбадашийн Мөнхбаяр
Бат-Очирын Энхнавч

Нэр дэвшүүлэх хороо

Далхжавын Батжаргал
Цэдэвсүрэнгийн Алтангэрэл
Бат-Очирын Энхнавч
Цагааны Баттогтох

УДИРДЛАГЫН БАГ



Б.МЯГМАР-ӨЛЗИЙ
Дархан Нэхий ХК
Гүйцэтгэх захирал



Б.ЧИНЧУЛУУН
Нэхий Таннери ХХК
Гүйцэтгэх захирал



З.ОЮУНТУЯА
Нэхий Гармент ХХК
Гүйцэтгэх захирал



Д.БУРМАА
Гранд ЯК ХХК
Гүйцэтгэх захирал



Б.ГЭРЭЛМАА
Нэхий Трейд ХХК
Гүйцэтгэх захирал



Б.ЧАНЦАЛ
Як Трейд ХХК
Гүйцэтгэх захирал



Г.ГАН-ОЧИР
Дэвжих Нэхий ХХК
Гүйцэтгэх захирал



Д.АРИУНСАЙХАН
Нэхий Агр ХХК
Гүйцэтгэх захирал

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ



Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлын товч мэдээлэл:

“Дархан нэхий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 21-ны өдрийн 12 цагт Дархан-Уул аймгийн Дархан сумын Үйлдвэрийн районд байрлах “Дархан нэхий” ХК-ийн хурлыг зааланд хийв.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 асуудлыг хэлэлцэж баталсан болно. Үүнд:

- Дархан нэхий ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.
- Дархан нэхий ХК-ийн дүрэмд өөрчлөлт, дагалдах журмуудыг батлав.
- ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаагаар сонгож, батлав.

ХОЛБОО БАРИХ

WE ARE AT YOUR SERVICE



БАЙРШИЛ

Дархан-Уул аймаг, Дархан сум,
Үйлдвэрийн район, Дархан нэхий ХК

Шуудангийн хаяг : Дархан- 213800

Шуудангийн хайрцаг : 901, Дархан
нэхий



И-МЭЙЛ

info@nekhii.mn

ficd@nekhii.mn



УТАС

7717-5555

7037-8499

8804-8903



<http://nekhii.mn/>

<http://yaktrade.mn/>

TRUE MONGOLIAN GENUINE LEATHER

